

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 2016

ОНЫ ЭХНИЙ 3-Р САРЫН ТЭСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар

2016 оны 1-р улирлын төсвийн орлогын төлөвлөгөөгөөр 1750608,9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1236985,6 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 70,6 хувиар биелүүлсэн дүнтэй байна. / Хүснэгтийг хавсаргав. / Үүнд:

- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 76950,5 мянган төгрөгөөр буюу 179,0 хувиар,
- Хог хаягдал 79927,7 мянган төгрөг буюу 122,2 хувиар тус тус давж биелсэн дүнтэй байна.
- Иргэний орлогын албан татвар 311359,9 мянган төгрөгөөр буюу 58,4 хувиар, Бууны татвар 5815,0 мянган төгрөг буюу 57,6 хувиар
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 104424,7 мянган төгрөгөөр буюу 56,4 хувиар
Ус рашаан ашигласны төлбөрт 31,6 мянган төгрөгөөр буюу 71,1 хувиар
Хүү торгуулийн орлого 207916,4 мянган төгрөгөөр буюу 5,49 хувиар тус тус тасарсан байна.
- Төсөвт газрын өсрийн орлогод 23105,3 мянган төгрөг, төвлөрүүлсэн дүнтэй байна.

Төлөвлөгөө давж биелэгдэж буй орлогын төрлүүдийн хувьд:

- Улсын тэмдэгтийн хураамжийн орлогоос Шүүхийн тэмдэгтийн хураамжаар төлсөн орлого буцах магадлалтай тул төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байдаг.
- Хог хаягдлын хураамжийн орлого нь Шинээр ашиглалтанд орж байгаа орон сууц хороололын хог тээврийн орлогыг нэг бүрчлэн явж хурааж байгаа нь төсвийн орлогын алдагдалын бууруулаж тасалдлыг нөхөж торгоож буй орлого болж байна.

Төлөвлөгөө тасарч буй орлогын төрлүүдийн хувьд:

- 2016 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн патент, жишиг-н хууль хүчингүй болж иргэний орлогыг ХХОАТ-ын хуулийн дагуу жилд нэг удаа тайлан гаргуулж тайланг үндэслэн албан татварыг хураадаг болсонтой холбоотойгоор өмнөх онуудын адил сар бүр хураах боломжгүй болсон. Иймд ХХОАТ-ын төлөвлөгөө биелэх боломж муутай байна.
- Бууны албан татвар орлого нь нийт 946 иргэн бууны төрлөөр бүртгэлтэй байдаг. Галт зэвсгийн тухай хуулийн 2015 оны 08 дугаар сарын 7-ны өдрөөс хэрэгжиж бууны албан татварын хувь хэмжээ нэмэгдсэн нь тухайн орлого тасалдаж байна гэж үзлээ.
- Дүүргийн хэмжээнд ус хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татварын бүртгэлд хамруулж, усны хэрэглээг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтэнд тулгуурлан тогтоож, татварт хамруулах ажлыг зохион байгуулах ажлыг, Дэд бүтэц тохижилтын хэлтэс зохион байгуулан ажиллаж байна.
- Хүү торгуулийн орлогоор 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хууль батлагдсанаас хойш төлөвлөгөөт татварын хяналт шалгалтын ажил хийгдээгүй мөн 2015 оны 08 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан “Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай” хуулийн 3.1 заалт: Энэ хууль 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаарна, 4.3 заалт: Хууль тогтоомж зөрчиж захиргааны

зөрчил гаргасан болон шийтгэл хүлээсэн этгээдийг өршөөн хэлтрүүлнэ гэж заасны дагуу 2015 оны 07 сарын 02-ны байдлаархи татварын хяналт шалгалтын хүү торгуулийн өр болох 1,500,000.00 мянган төгрөгийн өр тус хуулийн дагуу өршөөгдөж төсөвт төлөгдөх боломжгүй болсон тул 2016 оны татварын хүү торгуулийн орлогын төлөвлөгөө болох 1,000,000.00 мянган төгрөг биелэх боломжгүй гэж үзэж байна.

- Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын тасалдал нь улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа доголдож, өрийн сүлжээнд орсон, байрны сууц худалдан авах боломжгүй болсон нь эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан тодорхой хэсэг нь үйл ажиллагаагаа зогсоосонтой холбоотойгоор тасарч байна. Дүүргийн 2016 оны төсвийг орлогын тасалдал нь тухайн жилийн эдийн засгийн байдал хүнд байгаа зэрэг нь орлого бүрдэхгүй байх нөхцөл болж байна.

Хоёр.2016 онд Нийслэлийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийн талаар

2016 оны 1-р улирлын байдлаар нийслэлийн төсвөөс 883.328,4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас гүйцэтгэлээр 883.328,4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг санхүүжилтээ бүрэн авсан.

Гурав. Орон нутгийн төсвийн зарцуулалт, өр авлагын талаар

2016 оны 1 дугаар улирлын байдлаар орон нутгийн төсвөөс 17.574.263,2 мянган төгрөгийн зардал гаргах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 15.603.947,3 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгөөг 11.2 хувиар буюу 1.970.315,9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хүснэгтийг хавсаргав. /

Төсөвт зардлын гүйцэтгэлээс үзвэл:

- Үндсэн цалин, нэмэгдэл урамшил, унаа хоолны хөнгөлөлт, НДШимтгэл, бичиг хэрэг, гэрэл цахилгаан, түлш халаалт, тээвэр шатахуун, шуудан холбоо, гадаад албан томилолт, ном хэвлэл авах, эд хогшил худалдан авах, нормын хувцас зөөлөн эдлэл, урсгал засвар, төлбөр хураамж болон бусад зардал, зам талбайн цэвэрлэгээ, төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, орон нутгийн нөөц хөрөнгө, төвлөрсөн арга хэмжээ, байрны түрээсийн зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, гадаад зочны зардал зэргийг тус тус зардлын зүйлээр хэмнэгдсэн.
- Орон нутгийн төсөвт байгууллагуудын хувьд ИТХ-ын ажлын алба 127.974,6 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 80.016 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 47.958,6 мянган төгрөгөөр, ЗДТГ нь 1.402.723,4 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 1.207.289,3 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 195.434,1 мянган төгрөгөөр, Жаргалант тосгоны Захирагчийн ажлын алба нь 52.470,6 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 48.448,3 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 4.022,3 мянган төгрөгөөр, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь 22.399,4 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 20.858,9 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 1.540,5 мянган төгрөгөөр, Усан спорт сургалтын төв нь 47.986,4 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 42.082,5 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 5.903,9 мянган төгрөгөөр Худалдан авах ажиллагааны алба нь 29.145,3 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 22.501,4 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 6.643,9 мянган төгрөгөөр, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв нь 37.402,2 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 36.099,8 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 1.302,4 мянган төгрөгөөр, Дотоод аудитын алба нь 23.125,8 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 21.570,5 мянган төгрөгийн зардал

гаргаж төлөвлөгдсөн зардлыг 1.555,3 мянган төгрөгөөр, Амралт цогцолборын газар нь 17.576 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 15.562,7 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 2.013,3 мянган төгрөгөөр, Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний зардал нь 1.103.013 мянган төгрөгийн зардал гаргахаас гүйцэтгэлээр 753.131,3 мянган төгрөгийн зардал гаргаж төлөвлөгдсөн зардлыг 349.881,7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн дүнтэй байна.

- 2016 оны 1 дүгээр улиралд Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлуудын ажлууд хэрэгжиж эхлээгүй байна.

2016 он 1 дугаар улирлын байдлаар дүүргийн Усан спорт сургалтын төв нь хүмүүсээс авах авлага 200,0 мянган төгрөг байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудын хувьд төсвөөс төлөгдөх 94.503,9 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. ЗДТГ нь түлш халаалтын зардал дээр 11.008,2 мянган төгрөгийн өглөг, цэвэр бохир усан дээр 92,0 мянган төгрөгийн өглөг, Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал дээр 18.607,1 мянган төгрөгийн өглөг, Бараа үйлчилгээний бусад зардал дээр 55.007,5 мянган төгрөгийн өглөг, Усан спорт сургалтын төв нь нь Цалин хөлсний зардал дээр 2.857,7 мянган төгрөгийн өглөг, НДШ -ийн зардал дээр 6.316,1 мянган төгрөгийн өглөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь НДШ-ийн зардал дээр 615,5 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. / Хүснэгтийг хавсаргав. /

Хэмнэгдэж буй зардлын хувьд:

- Үйл ажиллагааны үе шат, цаг хугацааны хамаарлаас шалтгаалан бүх зардлын төрлүүд тус тус хэмнэлттэй гарсан байна. Тухайлбал оны эхний улиралд орлогын гүйцэтгэл нь нийт 768.308,8 мянган төгрөгөөр тасарсанаас байгууллагуудын санхүүжилт дутуу олгож, төсвийн гүйцэтгэл хэмнэгдэх болсон.

Дөрөв.2015 оны тусгай шилжүүлгийн орон нутгийн байгууллагын зарцуулалт,ер авлагын талаар

2016 оны эхний 1 дугаар улирлын байдлаар тусгай шилжүүлгийн байгууллагууд төсвөөс 15.282.666,6 мянган төгрөгийн зардал гаргах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 13.348.264,1 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан төлөвлөгөөг 12,6 хувиар буюу 1.934.402,5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг авч үзвэл төсвийн санхүүжилт 15.233.704 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 14.957.796,1 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлого 48.962,6 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 122.710,2 мянган төгрөг орсон байна. Төсөвт зардлын гүйцэтгэлээс үзвэл:

- Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бичиг хэрэг, түлш халаалт, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, шуудан холбоо, цэвэр бохир ус, албан томилолт, ном хэвлэл худалдан авах зардал, нормын хувцас зөөлөн эдлэл, урлаг уран бүтээлийн зардал, хичээл практикийн зардал, эд хогшил худалдан авах зардал, урсгал засварын зардал, татвар төлбөр хураамж, хоол, үдийн цай, эм, биеийн тамирын уралдаан тэмцээн, байрны түрээсийн хөлс, холбооны суваг ашигласны хөлс, газрын төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд тус тус хэмнэгдсэн байна.
- 2016 оны 1 дугаар улирлын байдлаар улсын төсвөөс төлөгдөх ер 728.360,5 мянган төгрөг байна.. Төлөгдөх ерийн 101.261,5 мянган төгрөг буюу 13,9 хувь нь цалин хөлс, 218,839,2 мянган төгрөг буюу 30 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийн ер, хоолны ер 233.448,2 мянган төгрөг буюу 32,1 хувь, гэрэл цахилгааны өглөг 763,2 мянган төгрөг буюу 0,1 хувь, түлш халаалтын өр 34.140,3 мянган төгрөг буюу 4,7 хувь, цэвэр бохир усны өр 5.139,5 мянган төгрөг буюу 0,7 хувь, шуудан холбооны

өр 165,0 мянган төгрөг буюу 0,02 хувь, бусад зардлын өр 134.603,6 мянган төгрөг буюу 18,5 хувь тус тус эзэлж байна.

2016 оны эхний 1 дүгээр улиралд 3.983,2 мянган төгрөгийн хүмүүсээс авах авлага байна./ Хүснэгтийг хавсаргав. /

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг улсын төсвийн байгууллагуудын төсвийн шууд захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд зардлыг санхүүжүүлэх дарааллыг тогтоож тэр хүрээнд төрийн сангаас төлбөр тооцоог гүйцэтгэх чиглэл барьж эрчимжүүлэн төсвөөс төлөх өрийг барагдуулах талаар анхааран ажиллаж байна. Зардлын гүйцэтгэлээс харахад зардлууд хэмнэлттэй харагдаж байгаа боловч гүйцэтгэлээр тооцоход цалин хөлс болон тогтмол зардлууд дээр 593.756,9 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. Энэхүү өглөгийг барагдуулахад анхаарч бусад зардлыг санхүүжүүлэхийг түр зогсоосноос хэмнэлттэй мэт харагдаж байна.

Өглөг үүсч байгаа шалтгааны хувьд

Төсвийн төлөвлөлт, хувиарлалт, цаг хугацааны хүчин зүйлийн нөлөөлөл, салбарын онцлогтой байдал, Нийслэлийн салбарын байгууллагуудаас ирсэн төсвийн хуваарилалтын онцлогоос шалтгаалан боловсролын байгууллагын цалин хөлс тогтмол зардал хүрэлцэхгүй өр үүсэх хандлагатай байна.

Дүгнэлт,цаашид анхаарах зарим асуудлын талаар

Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний энэ чиглэлийн ажлуудыг хариуцдаг хэлтсүүдээс төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, зарлага санхүүжилтийг оновчтой гүйцэтгэх, өрийг барагдуулах, төсвийн тэнцлийг ханган биелүүлэх чиглэлээр тавьсан зорилтоо тухайн улирлын түвшинд ханган биелүүлэхэд анхааран ажилласан болно. 2016 оны 1-р улирлын төсвийн гүйцэтгэлийн үр дүнг бататгах, төсвөөс төлөх өрийг барагдуулах чиглэлээр Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтсийн зүгээс цаашид дараахи чиглэлд анхааран ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх замаар төсвийн зарлага санхүүжилтийг хугацаанд нь гүйцэтгэж орон нутгийн төсөвт байгууллагуудын хэвийн жигд ажиллах нөхцөлийг хангах, төсвийг хэмнэх, орон нутгийн төсвийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх
2. Боловсролын салбарын төсөвт байгууллагуудын ажиллагсдын цалин хөлс, түлш халаалт, хоол зэрэг зардлууд хүрэлцэхгүй байгаа нөхцөл байдалд дигнэлт хийж, тооцоо судалгааг гарган холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР